ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08 дугаар сарын 03 өдөр Дугаар 70 Хэрлэн сум

LXX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 70 дугаар хуралдаан 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 12:00 цагт Хөлөнбуйр сумын морь барианы газарт 55 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Малын гоц халдварт шүлний өвчин бүртгэгдсэн аймаг, сумдаас ирсэн хурдан морьдыг уралдуулах эсэх талаар хэлэлцэх,

*Мал эмнэлгийн газар*

2. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийн цэг байгуулах эсэх талаар хэлэлцэх,

*Мал эмнэлгийн газар*

3. Хурдан морины уралдааны гараааны төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийн талаар хэлэлцэх,

*Мэргэжлийн хяналтын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн засаг даргын орлогч, Онцгой комиссын
Орлогч дарга Ч.Ганбат-д:

1.1. Малын гоц халдварт шүлхий өвчин бүртгэгдсэн аймаг, сумдруу албан бичиг хүргүүлэх,

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1.Хурдан морины уралдаанд оролцох морьдыг өөр аймаг, сумдаас ирэх, явах үед нь халдваргүйжүүлэлт хийх,

Гурав. Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа, Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн

/ / М.Бадамсүрэн
/ / Хур Г.Нармандах

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Хөлөнбуйр сумын Засаг дарга У.Ганхуяг нарт:

3.1.Хурдан морины уралдаанд оролцох морьдыг өөр аймаг, сумдаас ирэх, явах үед халдваргүйжүүлэлт хийх 2 цэг байгуулахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
327 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Цэцэнхүү,
Монголын морин спорт уяачдын холбооны
Дорнод аймаг дахь салбар хорооны тэргүүн С.Батмөнх нарт,

4.1.Хурдан морины уралдааны гарааны төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг шалгаж, засварлан бэлэн болгохыг,

Тав. Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга,
Онцгой комисссын гишүүн Ж.Алимаа-д:

5.1.Нисдэг дрон, хэмжилт хийх багаж хэрэгслийн төсвийг танилцуулахыг,

Зургаа. Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан,
Хөлөнбуйр сумын Засаг дарга У.Ганхуяг нарт

6.1.Хурдан морины уралдаанд оролцохоор ирсэн уяачдын отогт зөвлөмж өгөх 2 баг гаргаж ажллуулахыг,

Долоо.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

7.1. Хурдан морины уралдааны морь эргэх үед төв замын хөдөлгөөнийг түр хязгаарлахыг,

Найм.Аймгийн засаг даргын орлогч,
Онцгой комиссын орлогч дарга С.Ганбат-д:

8.1.Сэрвээний өндрийг хэмжих талбайн хэмжээг тодруулахыг,

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА Г.НАРМАНДАХ

/ / М.Бадамсүрэн

/ / Хур Г.Нармандах